



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 8/143

Мандалговь

Зохион байгуулалтын арга
хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "а", "ж", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 20 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн хугацааг сунгасантай холбогдуулан соёл урлаг, спорт болон олон нийтийг хамарсан бүх төрлийн үйл ажиллагааг 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хориглосугай.

Хоёр. Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй газруудын зөвхөн архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хуваарийг 2020 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал 09:00-20:00 цаг байхаар мөрдүүлсүгэй.

Гурав. Захирамжийг мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ж.Мөнхчулуун), аймгийн Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) болон холбогдох байгууллага, аж ахуй нэгжийн дарга, удирдлага, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



482010411